



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 31 өдөр

Дугаар 98/98

Арайхөөр

Бүх тендерээс татгалзах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2021 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 34 дүгээр дүгнэлтийн дагуу Сумын эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд эм, ороох боох материал нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн 1 дүгээр багц Яаралтай тусламж, мэдээгүйжүүлэх эм, 13 дугаар багц Дуслаар хэрэглэх амин дэм, 14 дүгээр багц Дотоодод үйлдвэрлэсэн эм, 15 дугаар багц Амин дэм, эрдэс бодисууд, 16 дугаар багц Дотоодод үйлдвэрлэсэн антибиотууд, 18 дугаар багц Эмнэлгийн хэрэгслийн багцуудаас татгалзсугай.

2. Дээрх багцуудад шууд гэрээ байгуулан, бараа нийлүүлэлтийн явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга (Д.Шивааннүрдэв)-д даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын нягтлан бодогч (Б.Валя)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

6222 31 0255

D: My Doc. Tushaal. ZDTG